

Эхийг уншаарай.**Дугуйтай жаал**

Манай хөрш айлд Төмөр гэдэг хүүхэд хотоос ирж амарсан юм. Тэр гялалзсан хар дугуйтай. Дугуйгаараа зогсоо зайгүй жирийлгэнэ. Хотон дундуур давхиж хонь үргээнэ. Түүгээр ч барахгүй нэг удаа Цэвээн эгчийн хувинтай сүүг дайрч асгаад бөөн хэл ам болсон. Түүнээс хойш “Чойжав гуайнд ирсэн энэ дугуйтай жаал үймүүлээд болохоо байлаа” гэсэн яриа гарав. Нэг удаа би гуйж байж дугуйг нь унах болов. Дугуй унаж огт үзээгүй болохоор хөдлөнгүүт л үсрээд ойчив. Төмөр тачигнатал инээж “Үгүй ээ, энэ Тогоогийн хөглөж байгааг. Дугуй ч унаж чадахгүй шүү” гээд л бараг тэр оройжингоо шоолж инээв.

Нэг өдөр Төмөр:

- Тогоо, чиний морийг унаж үзье гэхэд нь би:
- Чи морь унаж чадах юм уу? гэв.
- Чадахаар барах уу, хотод хүүхдийн парк гэж байдаг юм. Тэнд би бараг өдөр бүр эргүүлэгт тоглоом дээр морь унадаг гэхэд нь би зөвшөөрлөө.

Удсан ч үгүй Төмөрийн уйлах дуу хадах нь тэр. Юу болсныг гарч харвал тэр маань тушаатай морин дээр мордоод хөдлөх зуур ойчжээ.

- Чи морины тушааг нь авч мордохоо мэддэггүй юм уу? гэж асуухад,
- Үгүй ээ, би жинхэнэ амьд морь унаж үзээгүй гээд л бас уйлав.

Тогоо түүнийг өчүүхэн ч шоолсонгүй. Харин Төмөрийгөө буцахаас нь өмнө морь унуулж сургахаар шийдлээ.

Ч. Доржгочоо

1 Зохиолын баатрын хэлсэн үгийг сонгож дугуйлаарай.

- А. Төмөрийн уйлах дуу хадах нь тэр.
- Б. Би түүнийг өчүүхэн ч шоолсонгүй.
- В. Би жинхэнэ ийм амьд морь унаж үзээгүй
- Г. Цэвээн эгчийн хувинтай сүүг дайрч асгасан

2 Тогоо яагаад Төмөрийг морь унахыг зөвшөөрсөн бэ?

- А. Дугуйгаараа хонь үргээж, сүү асгасан учраас
- Б. Төмөр, Тогоод дугуйгаа унуулсан учраас
- В. “Чиний морийг унаж үзье” гэж хэлсэн учраас
- Г. “Парк орж, морь унадаг” гэж хэлсэн учраас

3

“Дугуйтай жаал” зохиолыг өөр сургуулийн хүүхдүүд уншсан. Тэд “Төмөрийн мориноос унасан нь хотод морь байхгүйгээс болсон” гэж үзсэн.

Чи үүнтэй санал нийлэх үү?

А. тийм

Б. үгүй

- Яагаад гэдгээ эхээс жишээ татан тайлбарлаарай.

4

Төмөр мориноос унахад Тогоо шоолоогүй. Тэгвэл Төмөр түүнд юу гэж хэлж болох вэ? Төсөөлөн бичээрэй.

5

Төмөр зуны амралтаа дуустал хөдөө байсан бол Төмөр, Тогоо хоёрт ямар үйл явдал тохиолдох бол? Таамаглан бичээрэй. (2-3 өгүүлбэр)

6

Балархай эгшиг нь эгшигт гийгүүлэгчийг эгшигжүүлсэн бүлэг үгийг сонгоорой.

А. бодож,
утас, намар

Б. самбар,
бөмбөг, эрдэс

В. үлгэр,
өвөл, бөмбөр

Г. талбай,
тугал, хавар

7

“Дугуйтай жаал” зохиолыг уншаад, төрсөн сэтгэгдлээ бичнэ үү.

(Үгийн тоо:40 – 45)

[illegible]